



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн аялал жуулчлал, амралтын Их шүтээн цогцолборын  
2022 оны санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот  
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг:  
narmandakhts@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Буян-ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг:  
Buynundrakhb@audit.gov.mn  
Аудитор: Ж.Наранчимэг  
Утас: 70359826 Цахим хаяг:  
naranchimegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/





**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.04.01 № 92

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН "АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛ, АМРАЛТЫН ИХ  
ШҮТЭЭН ЦОГЦОЛБОР"  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.МӨНХТОГОО ТАНАА

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Орхон аймгийн "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд санхүүгийн тайланг холбогдох материалын хамт ирүүлээгүй,

2. Аудитаар нийт 89,434.8 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн. Байгууллагын нягтлан бодогч 2021 онд 4,100 мянган төгрөг, тайлант онд 20 удаагийн үйлдлээр 14,528.3 мянган төгрөгийг хуурамч баримт бүрдүүлэн өөрийн дансанд шилжүүлэн авсанд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгагдаж байна, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн өглөг авлага үүсгэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант оны эцэст 64,710.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу 3,220.9 мянган төгрөгийн төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалингаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй 370.5 мянган төгрөгийн шимтгэл, татвар суутгаагүй байна. Байгууллагын захирлын тушаал, шийдвэргүй 2 ажилтанд 2,410.5 мянган төгрөгийн ажил хавсарсны нэмэгдэл

олгосон, үндэслэлгүй 1 ажилтанд 93.8 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.

### 3. Удирдлагын дотоод хяналт хангалтгүй

Эдгээр нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй зэрэг нь дүгнэлтийн үндэслэл болсон.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага тайлант онд зардлыг 8,360.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, мөнгөн хөрөнгө 9,210.6 мянган төгрөгөөр буурч 419.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлага 14,528.3 мянган төгрөг, Үндсэн хөрөнгө 196,065.9 мянган төгрөг, өр төлбөр 15,350.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

### **Аудитын гол асуудал**

Орон нутгийн хөрөнгө оруулалтын БЗА-36/19 дугаар гэрээгээр 194,615.9 мянган төгрөгийн үнийн дүнтэй "Бурхан багшийн сэрэг дүр"-ийн гадна тохижилтын ажлыг үндсэн хөрөнгөд хүлээн авч бүртгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Орхон аймгийн "Их шүтээн цогцолбор" ОНӨААТҮГ нь Эрдэнэт санд түрээсийн орлого 500.0 мянган төгрөгөөс өөр орлого төвлөрүүлдэггүй байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан, аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	178,600,464.18	134,093,726.67
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,629,946.18	419,298.67
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,629,946.18	419,298.67
4	Төгрөг	9,629,946.18	419,298.67
5	Арилжааны банк дахь харилцах	9,629,946.18	419,298.67
6	АВЛАГА	77,782,208	64,710,538
7	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,190,000	19,718,330
8	Бусад авлага	72,592,208	44,992,208
9	Байгууллагаас авах авлага	72,592,208	44,992,208
10	БАРАА МАТЕРИАЛ	91,188,310	68,963,890
11	Түүхий эд материал	90,212,310	68,060,790
12	Тусгай зориулалттай материал	90,212,310	68,060,790
13	Хангамжийн материал	976,000	903,100
14	Бичиг хэргийн материал	22,000	
15	Аж ахуйн материал	954,000	903,100
16	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,523,163,690.64	3,594,717,168.65
17	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,523,163,690.64	3,594,717,168.65
18	Биет хөрөнгө	3,523,163,690.64	3,593,739,043.68
19	Барилга, байгууламж, орон сууц	3,740,821,179	3,740,821,179
20	Хуримтлагдсан элэгдэл	-463,711,402.52	-529,144,253.72
21	Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,859,500	4,859,500
22	Хуримтлагдсан элэгдэл	-407,456.25	-1,385,351.25
23	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,492,567	52,492,567
24	Хуримтлагдсан элэгдэл	-13,364,592	-16,436,403.36
25	Бусад үндсэн хөрөнгө	256,554,689	451,370,660
26	Хуримтлагдсан элэгдэл	-54,080,793.59	-108,838,853.99
27	Биет бус хөрөнгө		978,124.97
28	Програм хангамж		1,250,000
29	Хуримтлагдсан элэгдэл		-271,875.03
30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,701,764,154.82	3,728,810,895.32
31	НИЙТ ӨР ТӨЛБӨР	821,962.76	998,893.78
32	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	821,962.76	998,893.78
33	Өглөг	821,962.76	998,893.78
34	Ажилчидтай холбогдсон өглөг	821,962.76	229,366.88
35	Бусад өглөг		769,526.9
36	Байгууллагад төлөх өглөг		670,000
37	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/		99,526.9

38	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,700,942,192.06	3,727,812,001.54
39	Засгийн газрын хувь оролцоо	3,700,942,192.06	3,727,812,001.54
40	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,205,925,201.85	4,400,541,172.85
41	Хуримтлагдсан үр дүн	-504,983,009.79	-672,729,171.31
42	Өмнөх үеийн үр дүн	-416,064,256.39	-504,983,009.79
43	Тайлант үеийн үр дүн	-88,918,753.4	-167,746,161.52
44	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,701,764,154.82	3,728,810,895.32

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	64,723,900	49,888,037
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,723,900	49,888,037
3	Нийтлэг татварын бус орлого	64,723,900	49,888,037
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,723,900	49,888,037
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,723,900	49,888,037
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	153,437,163.08	217,634,198.52
7	УРСГАЛ ЗАРДАЛ	153,437,163.08	217,634,198.52
8	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,437,163.08	217,634,198.52
9	Хангамж, бараа материалын зардал	964,250	
10	Аж ахуйн материал худалдан авах зардал	964,250	
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,995,129.55	92,921,705.53
12	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	45,603,874.55	73,378,880.04
13	Бусад зардал /ТӨҮГ/	12,391,255	19,542,825.49
14	Бараа үйлчилгээний бусад зардал	94,477,783.53	124,712,492.99
15	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,477,783.53	124,712,492.99
16	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-88,713,263.08	-167,746,161.52
17	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	205,490.32	
18	Найдваргүй авлагын алдагдал	205,490.32	
19	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-88,918,753.4	-167,746,161.52

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	64,723,900	69,937,087
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,723,900	69,937,087
3	Нийтлэг татварын бус орлого	64,723,900	69,937,087
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,723,900	69,937,087
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,723,900	69,937,087
6	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,377,180.79	78,297,734.51

7	УРСГАЛ ЗАРДАЛ	60,377,180.79	78,297,734.51
8	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,757,180.79	78,297,734.51
9	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,559,391.96	44,682,885.51
10	Үндсэн цалин	39,559,391.96	44,682,885.51
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,222,283.83	4,185,327
12	Тэтгэврийн даатгал	3,631,640.91	2,952,717.65
13	Тэтгэмжийн даатгал	403,668.37	306,939.15
14	ҮОМШӨ-ний даатгал	298,903.96	245,551.32
15	Ажилгүйдлийн даатгал	80,733.79	61,387.83
16	Эрүүл мэндийн даатгал	807,336.8	618,731.05
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,048,715	21,516,122
18	Гэрэл, цахилгаан	8,403,715	21,516,122
19	Цэвэр, бохир ус	645,000	
20	Хангамж, бараа материалын зардал	660,150	
21	Бичиг хэрэг	261,600	
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000	
23	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	238,550	
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,066,640	7,913,400
25	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,638,000	
26	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000	
27	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	36,640	
28	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		7,913,400
29	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000	
30	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000	
31	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	620,000	
32	Бусад урсгал шилжүүлэг	620,000	
33	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	620,000	
34	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,346,719.21	-8,360,647.51
35	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		850,000
36	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		850,000
37	Дотоод эх үүсвэрээр		850,000
38	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		850,000
39	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-850,000
40	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-8,120,399	
41	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	8,120,399	
42	Бусад зардал	8,120,399	
43	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-3,773,679.79	-9,210,647.51
44	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,403,625.97	9,629,946.18
45	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,629,946.18	419,298.67

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,201,065,701.85	-416,064,256.39	3,785,001,445.46
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,201,065,701.85	-416,064,256.39	3,785,001,445.46
3	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,859,500		4,859,500
4	Тайлант үеийн үр дүн		-88,918,753.4	-88,918,753.4
5	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,205,925,201.85	-504,983,009.79	3,700,942,192.06
6	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,205,925,201.85	-504,983,009.79	3,700,942,192.06
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,205,925,201.85	-504,983,009.79	3,700,942,192.06
8	Өмчид гарсан өөрчилөлт	194,615,971		194,615,971
9	Тайлант үеийн үр дүн		-167,746,161.52	-167,746,161.52
10	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,400,541,172.85	-672,729,171.31	3,727,812,001.54

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 14,538.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 14,538.3 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Үүнд: Банкны харилцах дансны үлдэгдэл 10.0 мянган төгрөгөөр зөрснийг, авлагын тодруулгад тайлант онд шинээр бий болсон 14,528.3 мянган төгрөгийн авлагыг тусгаагүй байсныг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 70,806.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 93.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 65,081.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 5,631.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

- Үндэслэлгүй 1 ажилтанд 93.8 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны иж бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.” гэж заасантай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **3.2 Албан шаардлага**

- УСНББОУС-1-н 27,28 дугаар зүйлийн дагуу санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаагүй. Байгууллагын удирдлагын дотоод хяналт сул, аудитаар 93.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 67,491.5 мянган төгрөгийн албан шаардлага, 3,221.0 мянган төгрөгийн зөвлөмж нийт 70,806.4 мянган төгрөгийн зөрчил илэрч сөрөг дүгнэгдсэн.

Энэ Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

- Байгууллагын эд хариуцагч солигдох үед хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.-д “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.2-д “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” гэж заасантай нийцэхгүй байна.

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн өглөг авлага үүсгэхгүй байх, ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалингаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутга гэсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тайлант оны эцэст 64,710.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, 370.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32.2-д “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан тохирсон хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ноогдуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

### **3.3 Зөвлөмж**

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Анхан шатны баримт иж бүрдэл дутуу, 3,220.9 мянган төгрөгийн төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны иж бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм." гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримт дутуу ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахгүй байх.

2. НББ, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь ашгийн төлөө байгууллага боловч ЖДААН-ийн СТОУС, Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалд нийцсэн санхүүгийн тайланг бэлтгэдэггүй, УСНББОУС болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалд нийцүүлсэн санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулж ирсэн уламжлалт эрсдэл тогтсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Энэ хуулийн 4.1.2-т заасан стандартыг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангах аж ахуйн нэгж, байгууллага мөрдөнө” гэсэн хэсэг, ЖДААН-ийн СТОУС, Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтад “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

ЖДААН-ийн СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэдэг байх.

3. НББ, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд байгууллагын захирлын тушаал, шийдвэргүй 2 ажилтанд 2,410.5 мянган төгрөгийн ажил хавсарсны нэмэгдэл олгосон байна. Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны иж бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хавсран нэмэгдлийг ажлын байрны тодорхойлолтод тусган нэмэгдэл олгохгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон аймгийн Их шүтээн цогцолбор ОНӨХК	2	14,538.3	1	14,528.3	1	10.0	2	14,538.3				

Дүн	2	14,538. 3	1	14,528 .3	1	10.0	2	14,538. 3				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Их шүтээн цогцолбор	1	93.8	1	93.8								
	1	0.0							1	2		
	1	0.0			1	0.0						
	1	65,081.0			1	65,081.0						
	1	3,220.9					1	3,220.9				
	1	0.0					1	0.0				
	1	2,410.5					1	2,410.5				
Дүн	7	70,806.2	1	93.8	2	65,081.0	3	5,631.4	1	2		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит хийсэн хэлбэр	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1					1	
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>					<b>1</b>	